

БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХӨЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ



### АЖЛЫН ХУВЦАС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20<sup>23</sup> оны 05-р сарын 22 өдөр

Дугаар №: 2023/40

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Пи Пи Пи Эм Жи Эл ХХК-ийг төлөөлж захирал Б.Баярбат /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

#### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Ажлын хувцас” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлнэ.

#### Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногт батгаан зуны хувцасыг болон ажлын сорочкан цамцыг нийлүүлнэ.  
Гэрээ баталгаажсанаас хойш 90 хоногийн дотор багтаан өвлийн хувцас нийлүүлнэ.

#### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 45,512,500 /Дөчин таван сая таван зуун арван хоёр мянга таван зуу/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид гүйцэтгэлээр төлбөр төлнө.
- 3.3 Ажлын зуны хувцас болон ажлын сорочгон цамцны төлбөр болох 21,972,500 /хорин нэгэн сая есөн зуун далан хоёр мянга таван зуу/-н төгрөгийг бараа нийлүүлснээс хойш 14 хоногийн дотор төлнө.
- 3.4 Үлдэгдэл төлбөр болох 23,540,000 /хорин гурван сая таван зуун дөчин мянга/-н төгрөгийг ажлын өвлийн хувцасыг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Худалдаа хөгжлийн банкны 406071718 тоот дансанд шилжүүлнэ.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам

- төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
  - 4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
  - 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Хангамжийн мэргэжилтэн М.Моломжав хариуцан ажиллана. Утас-99122684.
  - 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Пи Пи Пи Эм Жи Эл ХХК-ийг төлөөлж захирал Б.Баярбат хариуцан ажиллана. Утас- 93213355, 99080702.

### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгчийн шаардлагаар биелүүлэх үүрэгтэй.
- 5.3 Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрийн доголдолоос гарсан барааны гологдол зэрэг шаардлагад нийцээгүй ажлын хувцасыг буцаан өөрийн зардлаар засаж, залруулах үүрэгтэй.

### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад бараа хүлээн авах комисст хүлээлгэн өгнө.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.





## Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЭХ-ИЙН ДАРГАБӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ



Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН



Ц.МАНДАХСАЙХАН

ХУУЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ХАНГАМЖИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

М.МОЛОМЖАВ

### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ПИ ПИ ПИ ЭМ ЖИ ЭЛ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Б.БАЯРБАТ



Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

Хаяг: УБ хот БГД дүүрэг 16-р хороо Туул 20-416  
Утасны дугаар: 93213355,99080702  
РД:5408245

**Нийлүүлэх барааны жагсаалт**

№	Бараа материалын нэрс	Гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /НӨАТ/-эй
1	Ажлын хувцас /өвлийн/	Монгол	Хос	107	220000	23,540,000
2	Ажлын хувцас /зуны/	Монгол	Хос	135	115500	15,592,500
3	Сорочкон цамц	Монгол	Ширхэг	116	55000	6,380,000
	Нийт					45,512,500

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

“ПИ ПИ ПИ ЭМ ЖИ ЭЛ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



*M. Mollomjav*

М.МОЛОМЖАВ

*B. Bayarbat*

Б.БАЯРБАТ